

“МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2016 оны 4 дүгээр сарын 29 өдөр

Улаанбаатар хот

“Монгол Базалт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж Туушин зочид буудлын хурлын танхимд 15 цагаас хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хийж, 15 цаг 37 минутаас хуралдаж эхлэв. 41,244,951 ширхэг хувьцаатай 124 хувьцаа эзэмшигчид хуралд оролцож, 73.11 %-ийн ирцтэй байлаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг, хурлын дарга А.Энхгэрэл нээж, хурлын дэгийн танилцуулан хэлэлцэх асуудлыг танилцуулав.

1. Компанийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг ТУЗ-ийн дарга Ариунболд хувьцаа эзэмшигч нарт танилцуулав. Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар дэлгэрэнгүй танилцуулгыг Гүйцэтгэх захирал Энхгэрэл танилцууллаа.
2. ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчид, хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн талаар хурлын дарга Энхгэрэл танилцуулав. ТУЗ-ийн гишүүд болон шинээр нэр дэвшигч бүгд хувьцаа эзэмшигчдийн хуралд хүрэлцэн ирсэн байв.
3. ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулын хэмжээг хурлын дарга Энхгэрэл танилцуулав.
4. Компани хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг зөвшөөрөх эсэх тухайд хувьцааны арилжаа, арилжааны идэвхи, хувьцааны үнэ ханшийн талаар хурлын дарга Энхгэрэл танилцуулав.
5. Хайлах зуухны шинэчлэлийн хүрээнд үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, техник технологийн шинэчлэл, хэрэгжүүлж буй ажлууд, төслийн талаар ТУЗ-ийн дарга Ариунболд хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

Хурлын хэлэлцэх асуудлын дагуу танилцуулга хийгдсний дараа хувьцаа эзэмшигчид асуулт асууж, хариулт авав.

Хурлаар дараах асуудлаар хэлэлцэн санал хураав. Үүнд:

1. Компанийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах
2. ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулын хэмжээг тогтоох,

3. Компани хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг зөвшөөрөх эсэх
4. Хайлах зуухны шинэчлэлийн хүрээнд үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, техник технологийн шинэчлэл хэрэгжүүлэх төслийг батлах
5. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох.

Хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсаар дараах шийдвэр гарав:

Тооллогод 40,980,993 ширхэг хувьцаа эзэмшиж буй 103 хувьцаа эзэмшигчид саналын хуудсаар саналаа ирүүлэв. 263,958 ширхэг хувьцаа эзэмшиж буй 21 хувьцаа эзэмшигч саналын хуудсаа ирүүлээгүй байв.

1. Компанийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай асуудлаар хувьцаа эзэмшигчид 100 % зөвшөөрсөн.
2. ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулын хэмжээг тогтоох асуудалд хувьцаа эзэмшигчид 99.98 зөвшөөрсөн, 0.02% татгалзсан.
3. Компани хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг зөвшөөрөх эсэх тухай асуудалд хувьцаа эзэмшигчид 99.72 % зөвшөөрсөн, 0.24% татгалзсан, 0.01% түтгэлзсэн.
4. Хайлах зуухны шинэчлэлийн хүрээнд үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, техник технологийн шинэчлэл хэрэгжүүлэх төслийг батлах тухай асуудалд хувьцаа эзэмшигчид 99.52 % зөвшөөрсөн, 0.48% татгалзсан.
5. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг кумулятив аргаар сонгов.

Ердийн гишүүнээр:

1. А.Ариунболд 16.63 %-ийн саналаар
2. Г.Ганзориг 16.46 %-ийн саналаар
3. А.Энхгэрэл 16.50 %-ийн саналаар
4. П.Сайнбилэг 16.46 %-ийн саналаар
5. Б.Шаравсамбуу 16.49 % -ийн саналаар
6. Хан Гю Бунг 14.89 %-ийн саналаар

Хараат бус гишүүнээр:

7. Ш.Энхтөр 33.13 %-ийн саналаар
8. Ч.Зоригтбаатар 33.02%-ийн саналаар
9. Т.Цэнд-Аюуш 33.75%-ийн саналаар тус тус сонгогдлоо

БЭЛГЭ
УЛСЫН ТАР ХОТ
МОНГОЛ
БАЗАЛТ
ХК
0112484 - 111-2412484
ДУЛААН ТУСГААРГАЧ

МОНГОЛ
БАЗАЛТ
ХК